



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/002/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Бадрал Утас:70432545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

2025.02.02

№ 2/08

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл гэж үзсэн байна.

Аудитын гол асуудал

Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2024 онд 5 хөтөлбөрт 2,371,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 2,271,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж, 94,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг журмын дагуу тооцсон байна. Тайлант онд 1,065,767.2 мянган төгрөгийг эргэн төлөлтөөс, хугацаа хэтэрсэн авлагатай холбоотойгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 199,620.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн дэмжлэгийг тодорхой хугацаатай авсан ч хугацаа хэтэрсэн, эргэн төлөөгүй 101 хүнтэй холбоотой 287.0 сая төгрөг байгаагаас 53 хүнтэй холбоотой 121.7 сая төгрөгийг шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгүүлж байна. Нас барсан 56 хүнтэй холбоотой 56.5 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,363,472,012.0</u>	<u>5,147,226,312.88</u>
33	АВЛАГА	4,363,472,012.0	5,147,226,312.88
33300	Татаас, санхүүжилтийн авлага	227,858,492.0	-
335	Бусад авлага	4,135,613,520.0	5,147,226,312.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,135,613,520.0	5,147,226,312.88
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,363,472,012.0</u>	<u>5,147,226,312.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>31,500,000.0</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,500,000.0	-
413	Өглөг	31,500,000.0	-
4136	Бусад өглөг	31,500,000.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,331,972,012.0</u>	<u>5,147,226,312.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,331,972,012.0	5,147,226,312.88
512	Хуримтлагдсан үр дүн	4,331,972,012.0	5,147,226,312.88
51210	Өмнөх үеийн үр дүн	4,331,972,012.0	4,363,472,012.0
51220	Тайлант үеийн үр дүн	-	783,754,300.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,363,472,012.0</u>	<u>5,147,226,312.88</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,818,022,000.0	3,183,714,500.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,818,022,000.0	3,183,714,500.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,818,022,000.0	3,183,714,500.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,818,022,000.0	3,183,714,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,321,137,000.0	3,098,156,500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,931,000.0	85,558,000.0
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,327,954,000.0	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,904,813,918.0	2,399,960,199.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,904,813,918.0	2,399,960,199.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,573,824.0	90,292,680.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,573,824.0	90,292,680.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,573,824.0	90,292,680.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,823,240,094.0	2,309,667,519.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	829,083,684.0	561,962,902.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	829,083,684.0	561,962,902.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	932,440,410.0	396,759,410.0

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	932,440,410.0	396,759,410.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,716,000.0	85,558,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,716,000.0	85,558,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,265,387,207.12
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,265,387,207.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>913,208,082.0</u>	<u>783,754,300.88</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>913,208,082.0</u>	<u>783,754,300.88</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,818,022,000.0</u>	<u>3,411,572,992.0</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,818,022,000.0	3,411,572,992.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,818,022,000.0	3,411,572,992.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,818,022,000.0	3,411,572,992.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,321,137,000.0	3,098,156,500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,931,000.0	85,558,000.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,327,954,000.0	227,858,492.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,767,172,410.0</u>	<u>4,676,960,199.12</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,767,172,410.0	4,676,960,199.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,573,824.0	90,292,680.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,573,824.0	90,292,680.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,573,824.0	90,292,680.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,685,598,586.0	4,586,667,519.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,495,083,684.0	2,838,962,902.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,495,083,684.0	2,838,962,902.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	196,358,492.0	396,759,410.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,358,492.0	396,759,410.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,716,000.0	85,558,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,716,000.0	85,558,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	932,440,410.0	1,265,387,207.12
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	932,440,410.0	1,265,387,207.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(949,150,410.0)</u>	<u>(1,265,387,207.12)</u>
14	Бусад эх үүсвэр	949,150,410.0	1,265,387,207.12
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	949,150,410.0	1,265,387,207.12

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>949,150,410.0</u>	<u>1,265,387,207.12</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,331,972,012.00	0.00	4,331,972,012.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			31,500,000.00		31,500,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,363,472,012.00	0.00	4,363,472,012.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,363,472,012.00	0.00	4,363,472,012.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,363,472,012.00	0.00	4,363,472,012.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,363,472,012.00	0.00	4,363,472,012.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	783,754,300.88	0.00	783,754,300.88
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	5,147,226,312.88	0.00	5,147,226,312.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,098,156,500.00	2,929,255,582.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,098,156,500.00	2,929,255,582.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,100,000.00	90,292,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,100,000.00	90,292,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,100,000.00	90,292,680.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,001,056,500.00	2,838,962,902.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,001,056,500.00	2,838,962,902.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,001,056,500.00	2,838,962,902.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,098,156,500.00	2,929,255,582.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,098,156,500.00	2,929,255,582.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,098,156,500.00	2,929,255,582.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт санхүүжилт байхгүй.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100,268.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 63,000.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Өглөгийн тодруулга 31500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг 31500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Залруулагдаагүй нийт 37,268.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 37,268.8 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 37,268.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд бараа материалын тайланг санхүүгийн программд бүртгээгүй, бараа материалын тодруулга бэлтгээгүй нь Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавартай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бараа материалын тайлан гаргаж, тодруулга бэлтгэх.

3.1.2 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн дэмжлэгийг тодорхой хугацаатай авсан ч хугацаа хэтэрсэн, эргэн төлөөгүй 101 хүнтэй холбоотой 287.0 сая төгрөг байгаагаас 53 хүнтэй холбоотой 121.7 сая төгрөгийг шүүхээр болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлж байна. Үлдсэн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна.” гэсэн заалттай нийцээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах.

3.1.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.5, 6.4.8-д заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 171 мэдээлэл байршуулахаас жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх хугацаа болоогүйтэй холбоотой 2 мэдээллийг байршуулаагүй байна. 169 мэдээллийг хугацаанд нь байршуулсан харагдаж байгаа боловч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан батлагдсан төсвийг, 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлээгүй, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бүрэн оруулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээлэх ёстой мэдээллийг бүрэн мэдээлэх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөгийн тодруулга 31500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг 31500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	63,000.0	-	-	1	63,000.0	1	63,000.0	-	-
Дүн	1	63,000.0	-	-	1	63,000.0	1	63,000.0	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мян.төг)

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд бараа материалын тайланг санхүүгийн программд бүртгээгүй, бараа материалын тодруулга бэлтгээгүй.	1	37,268.8					1	37,268.8
Санхүүгийн дэмжлэгийг тодорхой хугацаатай авсан ч хугацаа хэтэрсэн, эргэн төлөөгүй 101 хүнтэй холбоотой 287.0 сая төгрөг байгаагаас 53 хүнтэй холбоотой 121.7 сая төгрөгийг шүүхээр болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлж байна. Үлдсэн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй.	1	-					1	-
Дүн	2	37,268.8	-	-	-	-	2	37,268.8

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мян.төг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.5, 6.4.8-д заасныг түүвэрлэн авч үзэхэд батлагдсан төсөв, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлээгүй, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бүрэн оруулаагүй байна.	1	-	-	-			1	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	1	1			1			
4	ТТЗ								

5	ТЭЗ								
	НИЙТ	1	1			1			